



1984 он
Техник Технологийн
Политехник Коллеж

ЗАХИРЛЫН ТУШААЛ

Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, V хороо, X хороолол,
Энх тайвны өргөн чөлөө -90, 16081 ш/х 389 Утас: 70007631, 70007620
www.ietpolytech.edu.mn И-мэйл: info@ietpolytech.edu.mn

Суралцагч элсүүлэх журам

Огноо: 20 22 оны 04 сарын 07 өдөр

Дугаар: 97

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2019 оны А/187 тоот тушаалаар батлагдсан "Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагад суралцагч элсүүлэх үлгэрчилсэн журам", Техник технологийн политехник коллежийн захиргааны зөвлөлийн 2022 оны 3-р сарын 25-ны өдрийн хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн **ТУШААХ** нь:

1. "Техник технологийн политехник коллежид 2022-2023 оны хичээлийн жилд суралцагч элсүүлэх журам"-ыг нэгдүгээр, мэргэжлийн чиглэл, хөтөлбөрийн жагсаалтыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.
2. Энэхүү журмын дагуу элсэлтийн үйл ажиллагааг зохион байгуулах, үр дүнг тайлагнахыг элсэлтийн комиссын гишүүдэд, журмын хэрэгжилтийг хангаж ажиллахыг тэнхимийн эрхлэгч, багш нарт тус тус даалгасугай.
3. Элсэлтийн үйл ажиллагаа, журмыг таниулах ажлыг зохион байгуулахыг Элсэлтийн комиссын нарийн бичиг /Ц.Орхонтуяа/, журмын хэрэгжилттэй холбогдон гарах зардлыг сургуулийн төсвөөс гаргахыг санхүү, төлөвлөлт эрхэлсэн захирал /Б.Батболд/ нарт тус тус үүрэг болгосугай.

ЗАХИРАЛ



Ц.БАЯРМАА

Захирлын 2022 оны 04-р сарын 07-ны өдрийн
97 тоот тушаалын нэгдүгээр хавсралт

**ТЕХНИК ТЕХНОЛОГИЙН ПОЛИТЕХНИК КОЛЛЕЖИД
СУРАЛЦАГЧ ЭЛСҮҮЛЭХ ЖУРАМ**



/2022-2023 ОНЫ ХИЧЭЭЛИЙН ЖИЛ/

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1 Техник Технологийн Политехник Коллеж /ТТПК/ -д суралцагч элсүүлэхдээ Хөдөлмөр, Нийгмийн Хамгааллын сайдын 2019 оны А/187 тоот тушаалаар батлагдсан "Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагад суралцагч элсүүлэх үлгэрчилсэн журам", 2022 оны 03 дугаар сарын 16-ны өдрийн МУ-ын Засгийн газрын 122-р тогтоолоор батлагдсан " Мэргэжлийн болон Техникийн боловсролын сургалтын байгууллагын суралцагчдад тэтгэлэг олгох журам" болон энэхүү журмыг баримтална.
- 1.2 Элсэн суралцахаар хүсэлт гаргагч, тэдний хэрэгцээ, хүсэл сонирхолд үндэслэн хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээ, ажил олгогчийн захиалгад нийцүүлэн элсэлтийн ажлыг зохион байгуулах элсэлтийн комиссын үйл ажиллагаатай холбоотой харилцааг энэ журмаар зохицуулна.
- 1.3 БШУ-ны сайдын баталсан мэргэжлийн чиглэл, хяналтын тоонд багтаан суралцагч элсүүлнэ.
- 1.4 ТТПК-д суралцагч элсүүлэх, бүртгэх, баталгаажуулах, мэргэжил сонголт хийлгэх, сургалтын гэрээ байгуулах үйл явц ил тод, шударга, шуурхай байна.

ХОЁР. ЭЛСЭЛТИЙН БҮРТГЭЛ, БАТАЛГААЖУУЛАЛТ

2.1 Элсэгчдэд тавигдах шаардлага

- 2.1.1 Мэргэжлийн боловсролын 2.5 жилийн сургалтад суурь боловсрол эзэмшсэн иргэн;
- 2.1.2 Мэргэжлийн боловсролын 1 жилийн сургалтад насанд хүрэгч иргэн;
- 2.1.3 Техникийн боловсролын 1.5 жилийн сургалтад тухайн мэргэжлээр мэргэжлийн боловсролын 2.5 жилийн сургалтад сурч мэргэжил эзэмшсэн иргэн;
- 2.1.4 Техникийн боловсролын 3 жилийн сургалтад бүрэн дунд боловсрол эзэмшсэн иргэн;
- 2.1.5 Мэргэжлийн сургалт болон мэргэшүүлэх сургалтад тухайн ажил мэргэжлийн ур чадвар олгох сургалтын хөтөлбөрөөс хамааран тодорхой чадамжийг эзэмших хүсэлтэй иргэн;

2.2 Элсэлтийн бүртгэл

- 2.2.1 Элсэлтийн бүртгэлийг сургуулийн www.ietpolytech.edu.mn/elselt - элсэлтийн вэб хуудсаар дамжуулан хийх бөгөөд элсэхийг хүсэгч өөрийн биеэр хичээлийн байранд ирж бүртгүүлж болно.
- 2.2.2 Элсэхийг хүсэгч нь элсэлтийн вэб хуудсанд нэвтэрч, шаардлагатай мэдээллийг үнэн зөв оруулан, бүртгэлийн хураамжийг төлж баталгаажуулна.
- 2.2.3 Намрын улиралд мэргэжлийн боловсролын 2.5 жилийн болон техникийн боловсролын 1,5, 3 жилийн сургалтад элсэхийг хүсэгчид 2022 оны 04-р сарын 1-



ний өдрөөс 2022 оны 08-р сарын 21-ний өдрийн хооронд, хаврын улиралд техникийн боловсролын 1.5 жилийн сургалтад элсэхийг хүсэгчид 2023 оны 01-р сарын 03-21 өдрийн хооронд тус тус бүртгүүлнэ.

- 2.2.4 Мэргэжлийн боловсрол олгох 1 жилийн сургалтын элсэлтийг мэргэжлийн онцлог, ажил олгогчийн захиалгат хугацааг харгалзан уян хатан зохион байгуулна.
- 2.2.5 Мэргэжлийн сургалтын элсэлтийг хяналтын тоонд тусгахгүй бөгөөд нийгмийн түншлэгчид, ажил олгогчдын эрэлт, захиалгын дагуу сургалтын байгууллагын хүчин чадал, орчинд нийцүүлж элсэлтийн хугацааг уян хатан байдлаар зохицуулан зохион байгуулж болно.
- 2.2.6 Хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг элсүүлэхдээ Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.1, 38.2 дахь хэсгийг үндэслэн элсэгчийн үнэмлэх, шийдвэрийг зохих баримт бичгийн бүрдэлд оруулна.


2.3 Мэргэжил сонголт

- 2.3.1 Мэргэжлийн боловсролын сургалтын өдрийн ангид бүртгүүлэгчийг сонгон шалгаруулахдаа суурь боловсролын гэрчилгээний дундаж оноо, ерөнхий суурь мэдлэгийн түвшин тогтоох шалгалтын оноогоор жагсааж хяналтын тоонд багтаан мэргэжил сонгуулна.
- 2.3.2 ЕБС-ийн 9-р ангийг тухайн онд В+ дээш үнэлгээтэй төгссөн төгсөгчийг онооны дараалал харгалзахгүй шууд мэргэжил сонгуулж болно.
- 2.3.3 Ажил олгогчдын гэрээ, захиалгаар болон орон нутгаас зохион байгуулалттай суралцах боломжийг бүрдүүлсэн бүртгүүлэгчийг онооны дараалал харгалзахгүй шууд элсүүлнэ.
- 2.3.4 Монгол дархан мэргэжлээр элсэгчдээс ур чадварын нэмэлт шалгалт авч болно.
- 2.3.5 Улс, бүс, хот, аймгийн хэмжээний олимпиад, уралдаан, тэмцээнд эхний таван байрт шалгарсан бүртгүүлэгчийг сонирхсон мэргэжлээр шууд элсүүлнэ.
- 2.3.6 Гадаадын иргэн бүрэн дунд боловсролтой дүйцэх боловсролтой, хэлний зохих бэлтгэлтэй бол сонирхсон мэргэжлээр шууд элсүүлнэ.
- 2.3.7 Бүртгэлийн хугацаанд бүртгэлээ цуцлах, бүртгэл дууссаны дараа өөр сургууль сонгох, зэрэг элсэх боломжгүй болсон тохиолдолд элсэлтийн хураамжийг буцаан олгохгүй бөгөөд шилжүүлэн тооцохгүй.
- 2.3.8 Элсэгч нь мэргэжлийн чиглэлээр хяналтын тоо дуустал мэргэжил сонголт хийж, ТТПК-д суралцах эрхийн бичиг олгоно. Суралцах эрхийн бичиг авсан хүнд дахин өөр хөтөлбөр, мэргэжил давхардуулан сонгохыг зөвшөөрөхгүй.

ГУРАВ. СУРАЛЦАХ ГЭРЭЭ

- 3.1 Суралцах эрхийн бичиг авсан элсэгч 2022 оны 08-р сарын 22-30 -ны өдрүүдэд бичиг баримтын бүрдүүлэлт хийж сургуулийн сургалтын албанд өөрийн биеэр ирж бүртгүүлнэ.
- 3.2 Элсэгч дараах материалыг бүрдүүлнэ. Үүнд:

Техникийн боловсролын сургалт /1,5 жил,3 жил/	Мэргэжлийн боловсролын сургалт /1жил, 2,5 жил /	Мэргэжлийн сургалт
1.Тусгай загварын өргөдөл	1.Тусгай загварын өргөдөл	1.Тусгай загварын өргөдөл
2.Боловсролын гэрчилгээ, мэргэжлийн үнэмлэх	2.Боловсролын гэрчилгээ	2.Өөрийн иргэний үнэмлэхийн хуулбар
3.Хувийн хэрэг	3.Хувийн хэрэг	3.3x4 хэмжээтэй тухайн оны фото зураг 1%

4.3x4 хэмжээтэй тухайн оны фото зураг 4%	4.3x4 хэмжээтэй тухайн оны фото зураг 4%	
5.Өөрийн иргэний үнэмлэхийн хуулбар	5.Өөрийн иргэний үнэмлэх /төрсний гэрчилгээ/, эцэг эхийн иргэний үнэмлэхийн хуулбар	
6.Бүртгэлийн хураамж	6.Бүртгэлийн хураамж	
7. Ажил эрхэлдэг бол ажлын газрын тодорхойлолт	7. Ажил эрхэлдэг бол ажлын газрын тодорхойлолт	4. Ажил эрхэлдэг бол ажлын газрын тодорхойлолт

- 3.3 Бүрдүүлэх материалыг хуурамчаар бүрдүүлсэн, материал бүрдэлт дутуу зэргээс холбогдон гарах хариуцлагыг бүртгүүлэгч өөрөө хүлээнэ.
- 3.4 Элсэгч нь бүртгэлээ баталгаажуулсны дараа сургалтын гэрээ байгуулж, сургалтын төлбөрөө төлснөөр суралцах эрхээр хангагдана.
- 3.5 Дээр дурьдсан хугацаанд ирээгүй, хүндэтгэх шалтгаанаа урьдчилан мэдэгдээгүй элсэгчдийг гэрээ байгуулахаас татгалзсан гэж үзэж элсэх эрхийг хүчингүй болсонд тооцно.
- 3.6 Элсэлттэй холбоотой мэдээллийг цахим сан бүрдүүлэн архивлана.
- 3.7 Суралцагч элсүүлэх үйл ажиллагаатай холбоотой хандив, энэхүү журамд зааснаас бусад төлбөр, хураамж авахыг хориглоно. Журмыг зөрчсөн багш ажилтанд хариуцлага тооцно.

ДӨРӨВ . БИЧИГ БАРИМТ БУЦААН ОЛГОЛТ, ХАРИУЦЛАГА

- 4.1 Сургуультай холбоогүй болсон бүртгүүлэгчид 8-р сарын 26-наас 10-р сарын 1-ний дотор бичиг баримтаа буцаан авч болно.
- 4.2 Элсэн суралцаагүй бүртгүүлэгчдийн бичиг баримтыг оюутан төгсөгчдийн алба сургуулийн архивт 2022 оны 10 сарын 15-ны дотор шилжүүлнэ.
- 4.3 Элсэгч нь техникийн боловсролын сургалтын суралцах эрхийн бичиг хүчингүй болгосон тохиолдолд 1 кредиттэй дүйцэх үйлчилгээний төлбөр төлнө. Мэргэжлийн боловсролын сургалтын суралцах эрхийн бичиг хүчингүй болгосон тохиолдолд хичээлийн жилийн сургалтын төлбөрийн 10%-тай тэнцэх төлбөр төлнө.

ТАВ. ЭЛСЭГЧДЭД ОЛГОХ СУРГАЛТЫН ТӨЛБӨРИЙН ХӨНГӨЛӨЛТ, ТЭТГЭЛЭГ

- 5.1 Элсэгчдэд сургалтын төлбөрийн хөнгөлөлт, тэтгэлгийг дараах хэлбэрээр олгох ба давхцуулж олгохгүй. Давхцсан тохиолдолд элсэгч аль нэгийг сонгоно.

№	Нөхцөл, шаардлага	Хөнгөлөлт, тэтгэлэг
Авьяас чадварыг дэмжих тэтгэлэг		
1	Суралцах мэргэжлийн чиглэлийн дагуу олон улс, үндэсний, бүсийн болон тус сургуулийн нэрэмжит олимпиад, уралдаан, тэмцээнд оролцсон бол	1-р байр 100% 2-р байр 50% 3 болон тусгай байр 30% Оролцсон-10%
2	Гадаад хэлний чиглэлээр олон улсын болон улс, бүсийн уралдаан, тэмцээнд оролцсон бол	1-р байр 30% 2-3 болон тусгай байр 20% Оролцсон-10%
3	Урлаг, спортын чиглэлээр олон улс, үндэсний, бүсийн уралдаан, тэмцээнд оролцсон бол	1-р байр 20% 2-3 болон тусгай байр 15% Оролцсон-10%

Нийгмийн байдлыг харгалзан сургалтын төлбөрийн хөнгөлөлт		
4	Нэг айлын 2-с дээш хүүхэд зэрэг суралцвал	2 бол аль нэг нь 30%, 3 бол аль нэг нь 50% /тус сургуульд нэгэн зэрэг сурдаг/
5	Улаанбаатар хотоос 500 км-ээс зайтай хөдөө орон нутгаас элсвэл	10%
6	Мэргэжлийн боловсролын 2,5 жилийн сургалтад дараах мэргэжлээр эмэгтэй хүүхэд элсэн суралцвал: - Автомашины засварчин - Гагнуурчин - Барилгын мужаан	10%
7	Хөгжлийн бэрхшээлтэй болон бүтэн өнчин элсэгч	50%
8	Монгол улсын засгийн газрын 2022 оны 03 дугаар сарын 16-ны өдрийн 122-р тогтоолын дагуу Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын 45 нас хүртлэх суралцагчдад төгсөхөд нь тэтгэлгийг нэг удаа олгоно.	
Хамтын ажиллагааг дэмжих, харъяа сургуулийн ажилтан болон ажилтны хүүхдэд дэмжлэг үзүүлэх, үнэнч үйлчлүүлэгчийг урамшуулах хөнгөлөлт		
9	Хамтын ажиллагааны гэрээтэй аж ахуйн нэгж, байгууллагаас 5 буюу түүнээс дээш ажилтан зэрэг элсвэл	тус бүр 10%
10	Сургуулийн төгсөгч шатлан суралцвал /тухайн жилдээ/	20%
11	ТТДС-ийн харъяа сургуулийн ажилтны хүүхэд болон өөрөө элсэн суралцвал /тухайн жилдээ/	25%

- 5.2 Оюутан төгсөгчдийн албаны хариуцсан мэргэжилтэн элсэгчийн хөнгөлөлт, тэтгэлгийг нотлох баримтад үндэслэн захирлын тушаалаар баталгаажуулан элсэн орсон дараагийн улирлын эцэст шийдвэрлэнэ. Суралцагч нь сургалтын төлбөрийн 50 хувиас багагүй төлсөн байна.
- 5.3 Дээрх хөнгөлөлт, тэтгэлэг тухайн хичээлийн жилд хүчинтэй байх ба жилийн чөлөө авсан тохиолдолд дараа жилд шилжүүлэн тооцохгүй.

ЗУРГАА . СУРГАЛТЫН ТӨЛБӨР, ТӨЛӨХ ЗАРЧИМ

- 6.1 Тухайн хичээлийн жилийн сургалтын төлбөрийн хэмжээг сургуулийн Удирдах зөвлөлөөс тогтооно.
- 6.2 Сургалтын төлбөр, түүнийг төлөх зарчмыг "Сургалтын гэрээ"-гээр зохицуулна